

2023 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Техник импорт ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц бүртгэх ажиллагаа 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 16 цаг 00 минутанд эхлэв.

Техник импорт ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлд 492 894 хувьцаа эзэмшдэг 2 хувьцаа эзэмшигч итгэмжлэлээр, 936 656 хувьцаа эзэмшдэг 6 хувьцаа эзэмшигч биеэр оролцохоор нийтдээ 1 429 550 хувьцаа эзэмшдэг 8 хувьцаа эзэмшигч бүртгүүлснээр 16 цаг 15 минутанд хурлын ирц бүртгэх ажиллагаа дуусав.

Бүртгэлийн ажиллагаа дууссаны дараа Хурал зохион байгуулах комиссоос хурлаар хэлэлцэх асуудлуудын талаарх танилцуулга, бусад холбогдох материал, саналын хуудсуудыг хувьцаа эзэмшигчдэд тарааж өгөв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дарга Д.Пүрэвсүрэн 1 429 550 ширхэг хувьцаа эзэмшдэг 8 хувьцаа эзэмшигч оролцож компанийн 1 446 755 ширхэг энгийн хувьцааны 98,8%-ийг бүрдүүлж байгаа тул Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2 дахь заалт, Техник импорт ХК-ийн "Дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 26 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай Хурлын даргад мэдээлснээр 16 цаг 20 минутанд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ажиллагаа эхлэв.

Хурлын даргаас хурлын дэгийг батлах эсэх асуудлаар санал хураахад нийт Хувьцаа эзэмшигчид зөвшөөрснөөр хурлын дэг, хурлаар хэлэлцэх асуудлууд батлагдав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу хурлаар хэлэлцэх асуудлуудын дарааллын дагуу ТУЗ-ын нарийн бичгийн дарга О.Бүжинлхам 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах, тус хурлаар хэлэлцэх асуудал, хурлын тооллогын комиссыг томилсон талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийн дагуу хурлын хэлэлцэх асуудлаар:

Хурлын дарга 2022 оны компанийн жилийн үйл аажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлтийг;

Техник импорт ХК-ийн Бизнес хөгжлийн албаны дарга Г.Уран-Өлзий 2022 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайланг;

ТУЗ-ын нарийн бичгийн дарга О.Бүжинлхам 2021 оны ногдол ашгийн тайланг,

Хурлын дарга 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, 2023 оны компанийн бүтэц, зохион байгуулалт, 2023 оны ТУЗ-ын гишүүнд нэр дэвшигчдийн талаар тус тус танилцуулав.

Хурлын дэгийн дагуу хурлаар хэлэлцэх асуудлуудыг хариуцсан албан тушаалтнаас танилцуулсны дараа Хурлын дарга, ТУЗ-ын гишүүд болон Г.Уран-Өлзий нараас хэлэлцэх асуудалтай холбогдуулан Хувьцаа эзэмшигчдээс асуусан асуултанд дараах нэмэлт тайлбар, мэдээллийг Хувьцаа эзэмшигчдэд өгөв.

Хурлын дарга: ТУЗ-ын гаргасан дүгнэлтийн талаар товч мэдээлэл өгөхөд өнгөрсөн оны хувьд компани маш амжилттай ажилласан. Анх удаагаа нэгж хувьцаанд 2000 төгрөг ногдуулсан. Өнгөрсөн онд цемент, битум борлуулж ажилласан. Ашиг 47%-иар өссөн. Цэвэр ашиг 8 тэрбум гарсан байгаа. Өмнөх оноос 5 тэрбум 500 саяар нэмэгдсэн. Ашиг нэмэгдчихээр татвар их төлөх болчихоод байна. Татварын тал дээр маш их анхаарахгүй бол ямар ч урам байхгүй байна.

Г.Уран-Өлзий: Тайлант жилд 2022 оны зорилтот чиглэлээр төлөвлөгөө биелсэн. Тайлант хугацаанд 2,8 тэрбум төгрөгийн татвар төлсөн. Гүйцэтгэх удирдлагын дэмжлэгтэйгээр ISO чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн. ISO-гийн баталгаажилтыг өнгөрсөн 7 хоногт авсан. Энэ жилийн хувьд 2023 онд манай компанийн 65 жилийн ой болно. Ойгоо угтаж ажлаа чанаржуулах, ажлын бүтээмжийг дээшлүүлэхтэй холбоотой олон талт үйл ажиллагааг зохион байгуулж явуулж байна.

Хувьцаа эзэмшигч С. Пүрэвжав: Мотоциклийн борлуулалтаар зах зээлд танайх хэдэн хувийг эзэлдэг вэ?

Г.Уран-Өлзий: Монголын зах зээлд 30%-тай байдаг. Энэ жил зүүн аймгууд руу чиглүүлж мотоциклийн борлуулалтаа хийх зорилготой байгаа. Энэ онд толовлогөөгөө 23%-иар давуулан биелүүлнэ гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Хурлын дарга: Та бүхэн манай тайлантай танилцсан уу?

Хувьцаа эзэмшигч Б.Ганболд: Танай тайлантай танилцсан. Өнгөрсөн онд ашигтай ажилласан байсан.

Хурлын дарга: Борлуулалтын өсөлтөд инфляци нөлөөлсөн. Цементийн үнэ нэмэгдсэн нь үнэ нэмэгдэж борлуулалт нэмэгдэхэд нөлөөлсөн. Энэ оноос эхлэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үйлчилгээ үзүүлэгч компаниас хүний нөөц, санхүү, борлуулалтын чиглэлээр зөвлөх үйлчилгээ авч эхэлж байгаа.

Хувьцаа эзэмшигч Б.Ганболд: Танай компанийн шийт хэдэн ажилтантай вэ?

Хурлын дарга: 62 хүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Хувьцаа эзэмшигч Б.Ганболд: Их цөөхөн ажилтантай юм байна.

Хурлын дарга: Тиймээ. Өнгөрсөн жилээс ISO чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж эхэлсэн. Энэ үйл ажиллагаатай холбогдуулан ISO-гийн стандартад зохицуулж компанийн ажилчдыг эрхэлж байгаа ажил, үүргийн чиглэлийнх нь дагуу бүтэц, зохион байгуулалтанд өөрчлөлт оруулсан. Компанийн бүтэц, зохион байгуулалтыг та бүхэнд дэлгэцээр харуулж байна. Энэ бүтцийг та бүхнээр батлуулах шаардлагатай байна. Та бүхэн танилцаад саналаа хэлнэ үү.

Хуралд оролцсон 8 хувьцаа эзэмшигч зөвшөөрч гараа өргөв.

Хувьцаа эзэмшигч Г.Гансүх: Хувьцаагаа хуваах уу? Хувьцаа худалдаж авмаар байна.

Хурлын дарга: Хувьцаандаа таарсан үнэлгээтэй хөрөнгөтэй байна. Хөрөнгийн үнэлгээ 30 тэрбумаар үнэлэгдсэн. Манай компанийн хувьцааны үнэлгээ хэд байна?

Хувьцаа эзэмшигч Б.Буянтогтох: Өндөр үнэлгээтэй байгаа. Өнөөдөр 20 гаран хувьцаа арилжаалагдсан.

Хурлын дарга: Хувьцаа хуваах асуудал дээр одоохондоо тодорхойгүй байна.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: Танайх хэдэн га газарт үйл ажиллагаа явуулдаг вэ?

Хурлын дарга: 5 га газарт үйл ажиллагаа явуулж байна. Энэ онд компанийн 2000 м.кв газрыг Япон улсын Нийгата мужийн Күбота брэндийн газар тариалангийн трактор, тоног төхөөрөмжийн showroom, засварын төвийн барилгыг барихад зориулсан. Засварын төвийг барих асуудлыг 4 жилийн өмнө хэлэлцэж шийдвэрлсэн байсан. Харамсалтай нь ковидын нөлөөгөөр хойшлогдож барилгын ажлыг өнгөрсөн жилээс эхлүүлж энэ онд барьж дуусган нээлтээ хийсэн. Барилгын нээлтийн үйл ажиллагаанд Япон улсын Нийгата мужаас 60 гаран хүн ирж оролцсон. Мөн нээлтийн үйл ажиллагаанд МУ-ын Ерөнхийлөгчийн биет төлөөлөгч, газар тариалангийн асуудал хариуцсан яам болон бусад төрийн байгууллагууд, монгол дахь Япон улсын элчин сайдын яам, УИХ-ын гишүүд ирж оролцсон сайхан үйл явдал болсон. Цаашдаа газар тариалангийн салбарыг өөдрөгөөр харж байна. Күбота брэндийн трактор, тоног төхөөрөмжийг борлуулахтай холбоотойгоор арилжааны банк болон газар тариалангийн бодлого боловсруулах чиглэлээр ажилладаг төрийн байгууллагуудтай хамтран ажиллахаар судалж байна.

Хувьцаа эзэмшигч Б.Ганболд: Тариаланчид хэр авах бол? Тэдэнд ямар нэгэн дэмжлэг, бодлогын асуудал байгаа юу?

Хурлын дарга: Япон улсынх гэдэг утгаар чанартай, үнэтэй байгаа. Мөн хуучин ч гэсэн чанартай трактор, тоног төхөөрөмжүүд ирж худалдаалагдаж байгаа. Тариаланчид төлбөрөө бүрэн төлж авна гэдэг хүндрэлтэй юм билээ. Тиймээс газар тариалангийн

салбарыг төрийн дэмжлэгтэйгээр авч явахгүй бол газар тариалан эрхэлнэ гэдэг хэцүү бэрхшээлтэй асуудал гэдгийг ойлгосон. Энэ тал дээр зохих байгууллагуудтай хамтран ажиллахаар тодорхой ажлууд хийгдээд явж байна. Газар тариалан эрхлэгчид маш талархалтайгаар хүлээж авч байгаа. 1986 онд анх Күбота брэндийн 1 ширхэг тракторыг Япон улсаас Монгол улсын Хөдөө аж ахуйн их сургуулийн сургалтанд зориулж тусламжаар өгч байсан юм билээ. Тэр трактор үнэхээр япон чанарыг харуулсан трактор байсан, зарим нэг эд анги нь муудаж эвдэрсэн ч гэсэн олон жил ашиглагдаад явж байсан, тэр үед тоног төхөөрөмж нь монголд орж ирсэн бол одоо хүртэл ашиглагдаад явж байх байсан болов уу гэж Хөдөө аж ахуйн их сургуулийн нэг багш анх охин компанийн нээлтийн үйл ажиллагаан дээр хэлж байсан. Манай улсад өөр олон төрлийн трактор орж ирж байгаа юм билээ. Күбота брэндийн трактор дэлхийд алдартай, чанараараа гайхагддаг. Бид чанартай бүтээгдэхүүн зах зээлд борлуулснаар түүнд тохирсон засвар, үйлчилгээг үзүүлэх, Күбота брэндийн нэр хүндийг өндөрт өргөж явах үүрэг, хариуцлага бидэнд ирж байна. Та бүхэн завтай үедээ ирж манай showroom, засварын төвийг ирж сонирхож үзээрэй.

Хувьцаа эзэмшигч Г.Содбилэг: Өнгөрсөн онд амжилттай ажилласанд сэтгэл хангалуун байна. Та бүхэнд ажлын амжилт хүсье.

Хурлын дарга: Энэ онд манай компанийн 65 жилийн ой болно. 12 дугаар сарын 08-ний өдөр ойн арга хэмжээ болно. Хуралдаа ирсэн Та бүхэн бүгдээрээ ирж оролцоорой. Урилга өгөх ажлыг ТУЗ-ын нарийн бичгийн даргад даалгаж байна. Үүнээс хойш компанитай холбоотой аливаа үйл ажиллагаанд хувьцаа эзэмшигчдээ урьж оролцуулж байхыг ТУЗ-ын нарийн бичгийн дарга хариуцаж байх хэрэгтэй байна. Хэлэлцсэн асуудлаар өөр асуулт байхгүй бол санал хураалт явуулахыг зөвшөөрч байна уу?

8 хувьцаа эзэмшигч санал нэгтэй зөвшөөрч байгаагаа илэрхийлж гараа өргөв.

Хурлын дарга: Хэлэлцсэн асуудлын талаар хурлаас гарах тогтоолын төсөлд саналын хуудсаар санал хураалт явуулья. Тооллогын комиссоос санал хураалт явуулж дүнг нэгтгэн танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Д.Пүрэвсүрэн: Саналын хуудсаар авсан санал хураалтын дүнг та бүхэнд танилцуулья. 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт 8 хувьцаа эзэмшигч оролцож саналаа өгсөн. Нийт тоологдсон саналын хуудас 8 байна. Үүнээс хүчинтэй саналын хуудас 8, хүчингүй саналын хуудас 0 дүнтэй тоологдсон. Холбогдох хууль, журамд заасны дагуу ТУЗ-ын гишүүдийг сонгохоор Хувьцаа эзэмшигчдээс өгсөн саналыг кумулятив аргаар дүгнэж гаргасан. Бусад хэлэлцсэн асуудлыг “зөвшөөрсөн” “татгалзсан” “түдгэлзсэн” хэлбэрээр санал авч саналын дүнг нэгтгэсэн. Саналын хуудсуудыг нэгтгэн дүгнэж үзэхэд хуралд оролцогч нийт 8 хувьцаа эзэмшигч бүгд хурлаар хэлэлцсэн 5 асуудлыг дэмжиж зөвшөөрсөн учраас 2023 оны Хувьцаа

эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүдийг баталгаажуулах шийдвэрийг гаргаж байна.

Хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцсэн асуудлуудыг Хувьцаа эзэмшигч та бүхэн зуун хувь /100%/ зөвшөөрч дэмжсэн тул хурлаас гарах тогтоолын төслүүдийг батлах шийдвэрийг гаргаж байна. Та бүхэнд ажлын амжилт хүсье. 65 жилийн ойд хүрэлцэн ирэхийг урьж байна. Хурал өндөрлөснийг мэдэгдэж байна.

Хурал 18 цагт дуусав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ын нарийн бичгийн дарга *О.Бүжинлхам* /О.Бүжинлхам/

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ